



ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН

ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан¹)

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 41 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 41.2 ДАХЬ ХЭСЭГТ "ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ЭНЭ ХУУЛИЙН 41.1.2, 41.1.4, 41.1.5-Д ЗААСАН ТОХИОЛДОЛД ЧӨЛӨӨЛӨХ, 41.1.3, 41.1.6, 41.1.7-Д ЗААСАН ТОХИОЛДОЛД ОГЦРУУЛАХ ТУХАЙ АСУУДЛЫГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭЖ ШИЙДВЭРЛЭНЭ." ГЭЖ ЗААСНЫ "... 41.1.3, ..." ГЭСЭН ЗААЛТ НЬ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь цэцийн шийдвэрийг орлохгүй ба цэцийн шийдвэрийн үндэслэлийг иргэд, олон нийтэд хүргэх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь Үндсэн хуулийн цэцийн их суудлын тогтоол болно.

Шийдвэрийн дугаар: 02

Шийдвэрийн огноо: 2023 оны 06 дугаар сарын 09-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт "Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ." гэж заасны "... 41.1.3, ..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ..." гэж заасныг зөрчсөн.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Мэдээлэл гаргагчийн тайлбар: "... Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт "Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн ... 41.1.3, ...-д² заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ..." гэснийг тус тус зөрчсөн. Учир нь хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тухайн шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолыг

¹Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

<https://legalinfo.mn/mn/detail?lawid=16759519155721>

² Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41.1.3 "гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан".



хэлэлцэхээр оруулахад төлөөлөгчид Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 хэсэгт³ заасны дагуу тухайн шүүхийн шийтгэх тогтоолтой холбоотой асуудлыг дурын төлөөлөгч хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал гаргаж, үүний дагуу санал хураалт явуулж олонхын саналаар хэдэн ч удаа хойшлуулж болохоор нөхцөл үүсгэсэн байна. Ингэснээр шүүхийн шийдвэр хэрэгжих боломжгүй болж, шүүхийн шийдвэрийг давсан хүчин чадалтай шийдвэрийг Хурлын Төлөөлөгчид гаргах боломжтой байдлаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийг шууд зөрчиж, шүүх эрх мэдэлд халдсан зохицуулалт болсон байна.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд гаргасан тайлбартаа "...Хуулиар тусгайлан олгосон бүрэн эрхийн хүрээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай асуудлыг хэлэлцэж байгаа болохоос "шүүх эрх мэдэл"-д халдсан, шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцэж байгаа хэрэг биш юм. Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол батлагдсанаар эхэлдэг бөгөөд төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох тохиолдолд Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх нь Үндсэн хууль зөрчөөгүй..." гэжээ

Үндсэн хуулийн цэцийн дунд суудал мэдээлэл гаргагчийн тайлбарыг үндэслэлтэй гэж үзэн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт "Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн ... 41.1.3 , ...-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ" гэж заасан нь Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэжээ. Уг дүгнэлтийг Улсын Их Хурал 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 22 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд гаргасан тайлбартаа "...Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан 6 үндэслэлээр төлөөлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохдоо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэхээр заасан нь нэг талаас Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн баталгааг хангах, нөгөө талаас иргэд, сонгогчдын төлөөлөл байх чадамж, тавигдах шаардлагыг хангуулах үүднээс хандаж буй хэрэг юм. Өмнө мөрдөгдөж байсан 2006 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлд огцруулах тухай тогтоол гаргахаар зааж зохицуулж ирсэн уламжлалтай бөгөөд одоогийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн холбогдох зохицуулалт нь мөн энэ уламжлалын дагуу шүүхийн шийдвэрийн агуулгыг хөндөхгүйгээр хэлбэрийн хувьд огцруулах шийдвэр гаргах агуулгатай юм ..." гэжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ, ЦЭЦИЙН ШИЙДВЭР

1. "...Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн Дунд суудлын хуралдаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан эрхийнхээ дагуу Хурлын төлөөлөгчид

³ МУЗЗНДНТУТХ-ийн 39.1.3 "хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асууж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах".



асуулт асууж хариулт авч, санал, дүгнэлт гарган санал хураалгаж болох бөгөөд уг асуудлыг ийнхүү хэлэлцэн шийдвэрлэхээр хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон этгээдийн гэм буруугийн асуудлыг, тодруулбал аливаа шүүхийн шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.⁴ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн холбогдох зохицуулалт шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг хөндөж байна..⁵ “...Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг нь бүх шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр, бүх байгууллага, хуулийн этгээд заавал биелүүлэх агуулгыг илэрхийлж байна. Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт *"Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн ... 41.1.3, ...-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ."* гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна..⁶ хэмээн дүгнэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт⁷ заасны дагуу маргааныг эхнээс нь дахин хэлэлцсэн. . “...Монгол Улсын Их Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” 22 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээ тусгаагүй байна..⁸ гэжээ.

2. Дээрх үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт *"Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ."* гэж заасны "... 41.1.3, ..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт *"Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ."*, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт *"Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ..."* гэж заасныг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай” хэмээн шийдвэрлэжээ.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоолын гурвын дүгнэлтийн үндэслэх хэсгийн 2 дахь цогцолбор.

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоолын гурвын дүгнэлтийн үндэслэх хэсгийн 3 дахь цогцолбор.

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоолын гурвын дүгнэлтийн үндэслэх хэсгийн 4 дэх цогцолбор.

⁷ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 *"Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана"*.

⁸ Үндэслэл хэсгийн 2 дахь цогцолбор.



---o0o---